

## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/85/СТА-ТӨҮГ

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	4
2.	Аудитын тайлан .....	6
2.1.	Оршил.....	6
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	6
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	7
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	8
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	9
2.8.1.	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл .....	9
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	11
3	Аудит хийсэн Санхүүгийн тайлан.....	12
3.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан.....	12
3.2	Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	14
3.3	Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан .....	15
3.4	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан .....	16
3.5	Аудит хийсэн 2018 оны зорилтот түвшин, төлөвлөгөөний биелэлт .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ҮЦК	Үнэт цаасны компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.03.15 № 06/446  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал О.Эрдэнэгэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Юнистар аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Тэрбиш ахлагчтай баг хариуцаж хэрэгжүүлэв.

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 01/40 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Компанийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

##### **Эрхэм зорилго:**

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК нь “Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн нэгэн гол хэсэг бүрэлдэхүүний хувьд, үнэт цаасны арилжааны дараах клиринг, төлбөр тооцоог шуурхай, найдвартай, тасралтгүй гүйцэтгэж, олон улсын жишигт нийцсэн үйлчилгээг үзүүлэх” гэж эрхэм зорилгоо тодорхойлжээ.

##### **Үйл ажиллагааны чиглэл:**

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээнд тус компанийн үйл ажиллагааны чиглэлийг “үнэт цаас арилжааны төлбөр тооцоо” гэж тодорхойлжээ. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны 73 дугаар тогтоолоор тус компанид олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд “үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагаа”, “үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа” эрхлэх гэжээ.

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн удирдлага нь дараах хууль болон Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус компанийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “СоларСис” програм хангамж ашигладаг байна.

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад эрсдэл бага байсан тул дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 1.0 хувиар сонгов.

Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь компанийн санхүүгийн гол үзүүлэлт орлого гэж үзсэнтэй холбоотой юм.

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 1,337.7 сая төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 13.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь эрсдэл дунд гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 9 асуудлыг алдаа зөрчилгүй гэж шийдвэрлэж, 2 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил байхгүй.

### **2.8.1. Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Компанийн дотоод нэгжийн хооронд 2,3 сая төгрөгийн авлага, өглөг үүсгэж бүртгэснийг залруулсан.
- Ашиглалтанд тавьж олгосон 8,5 сая төгрөгийн хангамжийн материалыг бараа материалын дансанд үлдэгдлээр бүртгэснийг тайлант хугацаанд хамаарах 1,2 сая төгрөгийг тайлант жилийн зардалд, өмнөх үед хамаарах 7,4 сая төгрөгийг хуримтлагдсан үр дүнд хааж залруулсан.

### **2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал**

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

## **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Мэдээллийн системийн болон дүрэм журмын шинэчлэл хийгдэж байгаа тул дараагийн аудитаар өөрчлөлтийн үеийн эрсдэл болон нийцлийг хянах. Мөн өмнөх аудитаар харилцагчдын мөнгөн хөрөнгийг ашиглаж хүүгийн орлого олж байгааг хуульд нийцүүлж журамлах зөвлөмж өгсний дагуу тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 17 дугаар тогтоолоор “*Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК дахь харилцагчдын мөнгөн хөрөнгө байршуулах журам*”



баталсан байна. Энэхүү журам Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад хуульд нийцэж байгаа эсэхэд анхаарал хандуулах шаардлагатай.

## **2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Компанийн удирдлага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21<sup>1</sup> дүгээр зүйлд заасны дагуу компанийн жилийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагын удирдлага нь батлагдсан төлөвлөгөө, зорилтот түвшин, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Сангийн сайдын 2018 оны 236 дугаар тушаалаар баталсан Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд зааснаар чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 7 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 452.3 сая төгрөгийн нийт зардал батлагджээ. 2018 оны гүйцэтгэлээр 437.9 сая төгрөгийн зардал гарч, зардлын гүйцэтгэл 97.0 хувьтай байна. Төлөвлөгдсөн зардал 14.4 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь гүйлгээний шимтгэлийн зардал 1.1 сая төгрөгөөр буюу 75.0 хувиар, дотоод томилолтын зардал 0.6 сая төгрөгөөр буюу 67.0 хувиар, хангамж, бичиг хэргийн зардал 1.4 сая төгрөгөөр буюу 28.0 хувиар хэмнэгдсэнээс голлон шалтгаалжээ. Харин нийт орлогыг 579.1 сая төгрөгөөр төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 1,337.7 сая төгрөгийн нийт орлого олж орлогын төлөвлөгөөгөө 231.0 хувиар биелүүлсэн байна. Орлогын төлөвлөгөө давж биелэхэд хувьцааны арилжааны шимтгэлийн орлого 276.2 хувиар, харилцах дансны хүүгийн орлого 159.4 хувиар биелсэн нь голлон нөлөөлсөн байна. Татварын дараах цэвэр ашиг 94.1 сая төгрөгөөр төлөвлөгдсөн бол гүйцэтгэлээр 805.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж ашгийн төлөвлөгөөгөө 856.3 хувиар давуулан биелүүлжээ.

Орлого, ашгийн төлөвлөгөө их хэмжээгээр давж биелсэн нь 2018 онд 5 компани шинээр хувьцаа гаргаж эдгээр хэлцлээс 549.0 сая төгрөгийн шимтгэлийн орлогын гэнэтийн өсөлт бий болсонтой холбоотой байна.

Батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

## **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус компанийн Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 7 зөвлөмж өгсөн ба зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна. Харилцагчдын мөнгөн хөрөнгийг ашиглаж хүүгийн орлого олж байгааг хуульд нийцүүлж журамлах зөвлөмжийн дагуу тус компанийн ТУЗ-ийн 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 17

дугаар тогтоолоор “*Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК дахь харилцагчдын мөнгөн хөрөнгө байршуулах журам*” баталсан байна. Энэ журам Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад хуульд нийцэж байгаа эсэхийг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай талаар 2.9-д дурдсан болно.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Арилжааны төлбөр тооцоо ҮЦК ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

**3 Аудит хийсэн Санхүүгийн тайлан****3.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 1-р сарын 01	2018 оны 12-р сарын 31
А	Б		
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	6,188,656,275.49	5,806,051,621.88
1.1.2	Дансны авлага	8,042,162.56	5,621,917.81
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	9,240.00	
1.1.4	Бусад авлага		19,852.00
1.1.6	Бараа материал	7,865,280.00	336,700.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	595,630.63	595,630.63
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>6,205,168,588.68</b>	<b>5,812,625,722.32</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	44,633,950.90	57,778,519.97
1.2.2	Биет бус хөрөнгө	1,287,603.20	11,437,603.20
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	936,123.03	1,914,881.40
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	2,791,716.67	
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>49,649,393.79</b>	<b>71,131,004.57</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,254,817,982.47</b>	<b>5,883,756,726.89</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	4,400,000.00	810.00
2.1.1.3	Татварын өглөг	3,912,969.17	58,491,150.48
2.1.1.4	НДШ-ийн өглөг		460,000.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		954,699,704.48

		2,173,123,539.61	
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,181,436,508.78</b>	<b>1,013,651,664.96</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	936,123.03	1,914,881.40
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>936,123.03</b>	<b>1,914,881.40</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>2,182,372,631.81</b>	<b>1,015,566,546.36</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч : - төрийн	950,893,520.75	4,000,000,020.75
2.3.6	Хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдэл		9,560,000.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	3,049,106,500.00	
2.3.9	Хуримтлагдсан ашиг	72,445,329.91	858,630,159.78
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>4,072,445,350.66</b>	<b>4,868,190,180.53</b>
<b>2.3.20</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,254,817,982.47</b>	<b>5,883,756,726.89</b>

**3.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>491,400,782.68</b>	<b>1,018,830,521.28</b>
2	Борлуулалтын өртөг		
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>129,762,319.97</b>	<b>1,018,830,521.28</b>
4	Арилжааны шимтгэлийн орлого	351,953,581.22	1,018,830,521.28
5	Хүүний орлого	69,067,756.46	318,809,599.58
8	Бусад орлого	70,379,445.00	49,000.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	341,748,530.78	416,857,794.82
12	Бусад зардал	19,889,931.93	22,174,710.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		19,656.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		- 72,419.48
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	129,762,319.97	898,603,852.56
19	Орлогын татварын зардал	7,032,562.90	92,750,762.91
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>122,729,757.07</b>	<b>805,853,089.65</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>122,729,757.07</b>	<b>805,853,089.65</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>122,729,757.07</b>	<b>805,853,089.65</b>
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

**3.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2016 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>950,893,520.8</b>	<b>0.0</b>	<b>-50,284,427.2</b>	<b>900,609,093.6</b>
2	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)			122,729,757.1	122,729,757.1
3	Өмчид гарсан өөрчлөлт	3,049,106,500.0			3,049,106,500.0
4	<b>2017 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>4,000,000,020.8</b>	<b>0.0</b>	<b>72,445,329.9</b>	<b>4,072,445,350.7</b>
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-7,395,289.8	-7,395,289.8
6	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			805,853,089.7	805,853,089.7
7	Бусад дэлгэрэнгүй орлого		9,560,000.0		9,560,000.0
8	Зарласан ногдол ашиг			-12,272,970.0	-12,272,970.0
9	<b>2018 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>4,000,000,020.8</b>	<b>9,560,000.0</b>	<b>858,630,159.8</b>	<b>4,868,190,180.5</b>

### 3.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>5,415,087,330,513.46</b>	<b>2,001,905,496,148.60</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	339,465,340.11	800,438,152.93
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	13,025,813.00	
	Буцаан авсан албан татвар /төлбөр/	138,144,232.62	
	Татаас, санхүүжилтийн орлого	3,049,106,500.00	
	Бусад мөнгөн орлого	5,411,547,588,627.73	2,001,105,057,995.67
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>5,409,932,561,853.89</b>	<b>2,002,558,250,374.06</b>
	Ажиллагчдад төлсөн	211,604,669.30	220,231,625.47
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	50,989,959.04	60,138,448.19
	Бараа материал худалдан авахад төлсөн	8,337,822.73	6,373,920.00
	Ашиглалтын зардалд төлсөн	8,121,748.81	19,187,467.18
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,136,218.00	3,443,740.00
	Татварын байгууллагад төлсөн	26,267,628.64	62,699,378.36
	Даатгалын төлбөрт төлсөн	13,091,153.00	
	Бусад мөнгөн зарлага	5,409,610,012,654.37	2,002,186,175,794.86
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>5,154,768,659.57</b>	<b>652,754,225.46</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>877,211,901.05</b>	<b>310,868,900.22</b>
	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	796,000,180.00	
	Хүлээн авсан хүүний орлого	81,211,721.05	310,868,900.22
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>768,003,270.00</b>	<b>28,446,358.37</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,207,523.00	17,646,358.37
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		10,800,000.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	763,795,747.00	

<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>109,208,631.05</b>	<b>282,422,541.85</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	<b>12,272,970.00</b>
	Төлсөн ногдол ашиг		12,272,970.00
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-</b>	<b>12,272,970.00</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>5,263,977,290.62</b>	<b>382,604,653.61</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>924,678,984.87</b>	<b>6,188,656,275.49</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>6,188,656,275.49</b>	<b>5,806,051,621.88</b>



**3.5 Аудит хийсэн 2018 оны зорилтот түвшин, төлөвлөгөөний биелэлт**

/мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				дүн	%
<b>А</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	<b>579,100.0</b>	<b>1,337,708.8</b>	<b>758,608.8</b>	<b>231.0%</b>
1.1	Хувьцааны арилжааны шимтгэл	350,000.0	966,645.6	616,645.6	276.2%
1.3	ЗГ-ын өрийн бичгийн шимтгэл /хоёрдогч/	7,500.0	1,704.6	-5,795.4	22.7%
1.4	Компанийн бондын арилжааны шимтгэл	1,000.0	97.3	-902.7	9.7%
1.5	Банк хоорондын гүйлгээний шимтгэл	2,600.0	2,950.4	350.4	113.5%
1.6	ҮЦК-иудаас төлбөр тооцоо гүйцэтгэсний үйлчилгээний шимтгэл /20 ҮЦК/	2,500.0		-2,500.0	0.0%
1.7	Интернет банкны үйлчилгээний хураамж	500.0		-500.0	0.0%
1.8	Гишүүнчлэлийн хураамж	15,000.0		-15,000.0	0.0%
1.9	Харилцахын дансны хүүгийн орлого	200,000.0	318,809.6	118,809.6	159.4%
1.10	ЗГҮЦ-ны хүүгийн орлого	-		0.0	
1.11	Бусад орлого	-	47,501.3	47,501.3	
<b>Б</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>452,316.0</b>	<b>439,104.9</b>	<b>-13,211.1</b>	<b>97.1%</b>
2.1	Цалин хөлс нэмэгдэл урамшуулал	218,454.9	203,073.1	-15,381.8	93.0%
2.2	Хоол унааны зардал	22,659.0	20,522.3	-2,136.7	90.6%
2.3	Байгууллагаас төлөх НДШ-12%	29,341.7	27,860.9	-1,480.8	95.0%
2.4	ТУЗ-ын цалингийн зардал	36,000.0	36,000.0	0.0	100.0%
2.5	ТУЗ-ын НДШ 11.8%	4,248.0	4,248.0	0.0	100.0%
2.6	Шагнал урамшуулал	2,100.0	1,900.0	-200.0	90.5%
2.7	Оффисын байрны ашиглалтын зардал	1,200.0	1,187.5	-12.5	99.0%
2.8	Оффисын байрны түрээсийн зардал	18,000.0	18,000.0	0.0	100.0%
2.09	Хангамж, бараа материал, бичиг хэргийн зардал	5,221.2	4,966.8	-254.4	95.1%
2.10	Маркетингийн зардал	1,530.0	1,474.9	-55.1	96.4%
2.11	Шуудан холбооны зардал	1,609.2	1,465.2	-144.0	91.1%
2.12	Интернетийн зардал	6,000.0	6,000.0	0.0	100.0%
2.13	Монгол банк сүлжээний гишүүнчлэлийн хураамж	4,800.0	4,800.0	0.0	100.0%

2.14	Мэдээлэл дамжуулах суваг ашигласны түрээс	1,425.6	1,425.6	0.0	100.0%
2.15	Тээврийн хэрэгсэл ашиглалтын зардал /шатахуун, сэлбэг/з/	5,352.0	4,479.3	-872.7	83.7%
2.16	Гадаад томилолтын зардал	10,000.0	9,989.0	-11.0	99.9%
2.17	Дотоод томилолтын зардал	870.0	290.0	-580.0	33.3%
2.18	Дотоод сургалт	1,486.0	1,486.0	0.0	100.0%
2.19	Арга хэмжээний зардал	12,010.0	11,311.3	-698.7	94.2%
2.20	Биеийн тамир уралдаан тэмцээний зардал	1,700.0	1,681.4	-18.6	98.9%
2.21	Тэтгэмжийн зардал	8,532.0	8,032.0	-500.0	94.1%
2.22	Аудитын зардал	5,500.0	4,400.0	-1,100.0	80.0%
2.23	СЗХ-ны шимтгэлийн зардал	35,000.0	47,432.7	12,432.7	135.5%
2.24	Элэгдлийн зардал/үндсэн хөрөнгө худалдан авалт/	17,461.0	16,524.7	-936.3	94.6%
2.25	Төлбөр хураамж жижиг татварууд	315.4	176.5	-138.9	56.0%
2.26	Гүйлгээний шимтгэлийн зардал	1,500.0	377.7	-1,122.3	25.2%
<b>В</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ АЛДАГДАЛ</b>	<b>126,784.0</b>	<b>898,603.85</b>	<b>771,819.9</b>	<b>708.8%</b>
<b>З</b>	<b>Орлогын татвар</b>	<b>32,678.4</b>	<b>92,750.76</b>	<b>60,072.36</b>	<b>283.0</b>
<b>Д</b>	<b>ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ (В+Г)</b>	<b>94,105.6</b>	<b>805,853.1</b>	<b>711,747.5</b>	<b>856.3%</b>



